

## ЗҮҮН ГАР УЛСЫН ХҮН АМЫН ТООНЫ АСУУДАЛД

И. САРУУЛ<sup>1</sup>, З. БАТСАЙХАН<sup>2</sup>

<sup>1</sup>МУИС, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Угсаатан судлалын тэнхим  
saruul@num.edu.mn

<sup>2</sup>МУИС, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи-археологийн тэнхим  
batsaikhan@num.edu.mn

Түлхүүр үг: Зүүн гар улс, Ойрад, хүн ам зүй, өрх айл

**ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ.** Алив улс орны хүн амын тоон үзүүлэлт нь тухайн ард түмний нийгэм – эдийн засгийн хөгжил, улс төрийн хүчин чадал, соёл иргэншлийн түүхийг бодитоор нь гаргах нэгэн суурь үндэслэл нь байдаг. Зохиогчид тус өгүүлэлдээ дундад зууны үеийн Монголын тусгаар тогтнолын сүүлчийн тулгуур болсон Зүүн гар улсын хүн амын тооны асуудлыг авч үзэв.

Дундад зууны үед манжийн Чин гүрнээс Монгол улсыг түрэмгийлэн эзлэхэд тусгаар тогтнолоо сахиж байсан сүүлчийн тулгар хэсэг нь улсын баруун жигүүрийн ойрад монголчууд байжээ. Ойрадчууд Зүүн гарын улсыг байгуулж, ХҮШ зууны тэргүүн хагаст Төв ба Дундад Азид нөлөө бүхий оршин тогтнож байээ. Түүхийн сурвалж ба судалгааны зохиолд ХҮШ зууны тэргүүн хагаст баруун монголчууд нь ойролцоогоор 200000 өрх буюу 600000 хүн амтай байсан гэж тэмдэглэсэнээс өөр судалгаа өнөө хир хийгдээгүй байна. Энэхүү тоог үнэн гэж үзвэл ойрадын нэг өрх нь 3 хүнтэй, аав ээж хүүхэд гурав л байж, хөгшчүүлийн тухай яригдахгүй, бүхэлдээ мөхөж яваа ард түмэн болж буй зөрчил илрэнэ. Ийм байдалтай Төв ба Дундад Азийг эрхшээлдээ барьж, нийгэм эдийн засгийн цэцэглэн мандалтад хүрч чадахгүй билээ. Иймээс эргэлзээтэй тоон үзүүлэлт байна.

Гадаад дотоодын эрдэмтдийн монгол өрхийн судалгаанаас үзвэл дунджаар нэг айл 5 хүний бүрэлдэхүүнтэй байжээ. Тэгвэл 200000 өрх нь 1000000 хүн ам болно. Үүний дээр Дундад Азид тархсан харъяатуудыг нь хамгийн багаар тооцоход 500000-аас доошгүй байна. Иймд зохиогчид ойрад монголчуудын хөгжилд нөлөөлж байсан бусад хүчин зүйлүүдийг тооцон Зүүн гар улс нь 1500000-аас 1800000 хүн амтай байжээ гэж үзэв.

Анх академич Н. Ишжамц 1966 онд “БНМАУ-ын түүх”-ийн II ботид (1985):  
- “Бүгд бодвол тэдний хааны хорин дөрвөн отог, есөн жас ба жич олон тайшийн хорин нэгэн ангид хорь илүү түм өрх, жар илүү түмэн ам буй” гэснээс хойш монголын түүхчид өдгөө хүртэл тус заалтыг баримтлан судалгаа шинжилгээний эргэлтэнд хэвээр хэрэглэж буй. Тухайлбал, Д. Гонгор “Халх товчоон” бүтээлдээ: - “Дөрвөн ойрадын байдлыг авч үзэхүл хааны хорин дөрвөн отог, есөн жас, тайш нарын хорин нэгэн анги бүгд хорин түмэн өрх, жаран түм илүү хүн ам байсан” (Гонгор, 1978), А. Очир “Монголын ойрадуудын түүхийн товч” товхимолд: - “Зарим мэдээгээр манжийн түрэмгийлэгчид довтолох үед Зүүн гарын улс 600000 орчим хүн амтай

*байсан*” (Очир, 1978), хамгийн сүүлийн үеийн байдлаар 2003 онд хэвлэгдсэн Монгол төрийн Ү боть *“Монгол улсын түүх”*-ийн (2003) дөтдүгээр ботид: - **“ХҮШ зууны эхэн хагасын үед Зүүн гарын хаант улсын нийт өрх нь 200000 орчим, хүн ам нь 600000 орчим байсан байна”** гэсэн нь ямар ч сурвалжийн ишлэл заалтгүй болжээ.

Үүний зэрэгцээ өвөр монголд нийтлэгдсэн “Ойрад түүхэн сурвалж бичиг” (1985) зохиолд: - **“... өрхийн тоо есөн түм гурван мянга есөн зуу (93900) хүрч, хүн амын тоо жаран хоёр түмд (620000) хүрсэн юм”** гэсэн нь тун хачин үзүүлэлт болно. Тэгэхлээр монголын түүх бичлэгт манай эрдэмтдээс Зүүн гар улсын хүн амын тооны асуудлыг өнөө хүртэл шалгасан судалгаа хараахан байхгүй нь тодорхой тул зохиогчид нягталбаас:

*Нэгдүгээрт*, Академич Н. Ишжамц (1968) Л. Дэндэвийн (1936) манж хэлнээс монголд хөрвүүлсэн *“Тэнгэрийн тэтгэсэн хааны богд сургаал”*-аас иш татсан нь зүүн гарын хүн амын тоог тэмдэглэсэн ганцхан сурвалж мэт ойлгогдож буй. Тэгвэл 1990 онд оросын эрдэмтэн А.И. Чернышев ойрадын нийгэм-эдийн засгийн асуудлыг судлахдаа нангиадын *“Циньдин хуаньюй Сиюй тучжи”*-гийн 29-р талд Зүүн гар улсын хүн амын тооны заалт байгааг тэмдэглэжээ. Иймд манж, нангиад болон бусад хэлний сурвалжуудыг сайтар хянаад харьцуулсан шинжилгээ хийх шаардлагатай болно;

*Хоёрдугаарт*, Монголчууд Тэнгэрийн тэтгэсэн хаан гэж цоллох буюу Цяньлун нь 1736-1796 онд 60 гаруй жилийн хугацаанд манжийн Чин улсын хаан суусан. Тэгвэл Зүүн гарын улс нь 1636-1758 оны хооронд тогтносон болохоор *“Тэнгэрийн тэтгэсэн хааны богд сургаал”* сурвалжийн хүн амын тооны үзүүлэлт нь сүүлийн 20-иод жилд хамаарна;

*Гуравдугаарт*, *“Тэнгэрийн тэтгэсэн хааны богд сургаал”* сурвалжийн заалт нь Зүүн гар улсыг нийт 200000 өрх буюу 600000 хүн амтай гэжээ. Тэгвэл ойрадын нэг өрх нь эцэг, эх, хүүхэд гэсэн гуравхан хүний гишүүнчлэлтэй, айл болгон ганцхан хүүхэдтэй болж таарч, хөгшчүүлийн тухай бүр ч яригдахгүй. Өөрөөр хэлбэл, ойрадын хүн ам тогтмол хорогдож, мөхлийн ирмэг дээр тулсан болно. Энэ нь түүхэн байдалд ер нийцэхгүй бөгөөд 600000 гэсэн тоо нь худлаа үзүүлэлт байна. А.И. Чернышев: - **“Зүүн гар улс 600000 хүн амтай гэсэн тоо нь тун эргэлзээтэй”** гэсэн нь зүйтэй юм.

Мөн өвөр монголын судлаач Намсрайн тэмдэглэснээр зөвхөн зүүн гарын хуучин **“арван хоёр отог нь Цэвээнравдан ханы үед хүн ам нь жаран түм (600000) хүрч, отог бүрийн ам тоо нь дунджаар таван түм (5000) шахам**

**болсон**", мөн өвөр монголын Бадай, Алтан-Оргил нар ойрадын **"хүн амын тоо жаран хоёр түмд (620000) хүрсэн юм"** гэсэн нь бидний эргэлзээг давхар баталж буй. Зүүн гарын улс нь нийгмийн захиргааны бүтцийн хувьд хуучин 12 отгийн дээр сүүлийн байгуулагдсан 12 отог, 9 жас, 21 ангитай байсан тул 600000 гэсэн үзүүлэлт нь дөнгөж хүн амын гуравны нэг хэсэгтэй л тэнцэж байна. Эндээс Зүүн гарын улс нь ойролцоогоор 1800000 орчим хүн амтай байсан болбуу.

**"Тэнгэрийн тэтгэсэн хааны богд сургааль", "Циньдин хуаньюй сиюй тучжи"** зэрэг сурвалжуудад тэмдэглэгдсэн **жаран түм** буюу **600000** гэсэн тоон үзүүлэлт гарсан түүхэн нөхцлийг тодруулбал **"Манжийн цэрэг ойрадыг түрэмгийлж эзлэхдээ хүн амыг нь үндсэнд нь устгаж, газрын хөрснөөс арилгасан"** явдал нь Зүүн гарыг эргэж сэхэхээс айж, дахин босч ирэх сэхээгүй болгосон байна. Зарим мэдээгээр ойрадын харъяаны нийт хүн амын 90%-ийг устгаад шинэ баруун хязгаарыг урд өмнө таран сарнисан ойрадчуудыг цуглуулж байгуулсан нь 600000 хүн амтай байжээ. Тиймээс А.И. Чернышев **"Зүүн гар улсыг түрэмгийлэн эзэлсний дараа гарч ирсэн тоо"** гэсэнтэй бид санал нийлж буй;

**Дөрөвдүгээрт**, Сурвалж, судалгааны зохиолуудад Зүүн гарын хүн ам даангүй ХҮШ зууны тэргүүн хагаст их өссөн тухай бичсэн байдаг. Тухайлбал, 1985 онд өвөр монголын Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ нар хамтран эмхэтгэн тайлбарласан **"Ойрад түүхэн сурвалж бичиг"** бүтээлд: - **"Зүүн гарын хаант улс байгуулагдсан 1679 оноос Чин улсад мөхөгдөх хүртэл 80-аад жилийн хооронд түүний хүн амын тоо бараг нэг дахин намэгджээ. Чин улсад мөхөгдөх үед Зүүн гарын хаант улсын эл аймгийн феодал ноёдын захиргаан доорх хорин нэгэн ангиас гадна жинхэнэ отгийн тоо хуучин арван хоёроос хорин дөрөв болж, жасын тоо өнгөрсөн таваас ес болж бараг бүр нэг дахин нэмэгдсэн"**, 1990 онд А.И. Чернышев: - **"Ойрад аймгууд нь нутаг дэвсгэр хүрэлцэхгүй шахцалдаж байсны улмаас шинэ бэлчээр нутаг орон шаардагдаж байсан тухай сурвалжийн мэдээ сэлт цөөнгүй буй. Тэгээд ч зогсохгүй Зүүн гарын хануудаас Хаант Орост хандаж, ард түмнээ Эрчис мөрний сав газраар нутаглахыг зөвшөөрөхийг хүсч байжээ. Энэ бүхэн нь өсч байсан гэсэн санал зөв болохыг баталж байна"**.

Бид мөн энэ саналтай нийлж байгаа юм. Хэдий дайн байлдаанд цэрэг эрс үрэгдэж байвч Зүүн гарын улс нь Цэвээнравдан, түүний хүү Галданцэрэн хануудын үед дөрвөн ойрадын үндсэн отгийн тоо олширч 24-т хүрсэн, жас нь 5

байснаа 9 болсон, анги нь 21 байсны дээр нутаг ус хүрэлцэхгүйн улмаас хошоодууд Хөх нуурт, торгуудын Хо өрлөг тайш албатаа дагуулан Ижил, Зайд очиж суурьшсан түүхийг бодолцвол яах аргагүй хүн ам нь эрчимтэй өсч байжээ;

*Тавдугаарт, - Нүүдэлчин монголчуудын өрхийн гишүүдийн дундаж тоог эрдэмтэн судлаач нар янз бүрээр тогтоож байжээ. Тухайлбал, Н.Я. Бичурин (1842), Г.С. Паллас (1776), С.И. Руденко (1961), Н.М. Майский (1959), сүүлийн үед Г.С. Горохова (1980) нараас монголчуудын гэр бүл дунджаар таван хүнтэй байсныг нотолцгоожээ. Үүний дээр нангиадын "Сичуй цзунтун шилюз" сурвалжид: - "Ижил мөрнөөс Зүүн гар руу 33000 өрх, эсвэл 169000 хүн нүүж очжээ" гэсэн мэдээг А.И. Чернышев ишлэн өрхийн дундаж нь таван хүнтэй байсныг давхар баталж, энэ үндсэн дээр "Нангиад сурвалжийн мэдээлсэн 200000 өрх гэсэн тоонд эргэлзэх зүйлгүй. ... Хэрвээ ойрадын нийт өрх нь 200000, өрхийн гишүүний дундаж таван хүн бүрдүүлж байсан гэж үзвэл ойрадын хүн ам нь 600000 бус, харин сая илүү байсныг зөвшөөрөн хүлээх нь гарцаагүй ... тэхдээ Зүүн гарын улсад зөвхөн ойрадууд оршин сууж байгаагүй. Үүнээс үндэслээд Зүүн гарын захиргаанд байсан Дорнод Туркестан, бусад ард түмнийг оруулаад тооцвол ойролцоогоор 1,5 сая хүн ам илүү давж байжээ", 1996 онд өвөр монголын судлаач Намсрайгаас "Тэнгэр уулын ар өврийн өргөн уудам нутаг дэвсгэрт дөрвөн ойрадаас гадна бас лалын шашинтны монголчууд (Цагаадайн хойч үрс), уйгур, хасаг, хиргис, хотон, тажик, татарын бухар, бурууд, мянгад, тэлэнгэд зэрэг аймаг үндэстнүүд нутагшин оршиж ... адил бус үг хэлийг хэрэглэн, мал тариалан болон гар үйлдвэрлэлийг түшиглэн аж төрөх эдгээр аймаг үндэстний (дөрвөн ойрад багтаж буй) хүн ам нь тэр хирд зуун тавин түм (1500000 – И.С.) хэтэрч байсан" гэсэн нь бидний 1800000 гэсэн ойролцоо тооцоотой авцалдаж буй.*

Эцэст нь тэмдэглэхэд урьд өмнө судлаачдаас Зүүн гарын хүн амын тоог тогтоосон баримтууд нь шинжилгээ судалгааны арга зүй дутагдсанаас буруутахад хүрчээ. Бидний үзэж байгаагаар Цэвээнравдан, Галданцэрэн хануудын цагт ойрадын харъяаны нийт хүн ам нь ойролцоогоор 1500000-1800000; түүнээс зөвхөн хуучин 12 отогт 620000 илүү нь нутаглаж байсан нь Зүүн гарын улс нь хүчирхэгжиж, нийгэм эдийн засгийн цэцэглэн мандалтынхаа оргилд хүрч, Төв ба Дундад Азид нөлөө бүхий улс болсон үндэс нь байжээ.

## НОМ ЗҮЙ

- Бичурин Н.Я., 1842. Статистическое описание Китайского государства. Т. 1-2. Спб.  
БНМАУ-ын түүх, 1966. Боть П. УБ  
Гонгор Д., 1978. Халх товчоон. УБ  
Горохова Г.С., 1980. Очерки по истории Монголов в эпоху маньчжурского господства. М.  
Майский И.М., 1959. Монголия накануне революции. М.  
Монгол улсын түүх, 2003. Дөтдүгээр боть. УБ  
Намсрай, 1996. Зүүн гарын хаант улсын түүх. Өвөрмонгол  
Ойрад түүхэн сурвалж бичиг, 1985. Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ нар эмхэтгэн тайлбарлав. Өвөр Монгол  
Очир А., 1993. Монголын ойрадуудын түүхийн товчоон. УБ  
Паллас П.С., 1776. Собрание исторических известий о Монгольских народах, Спб.  
Руденко С.И., 1961. К вопросу о формах скотоводческого хозяйства и о кочевниках. Географическое общество СССР. Материалы по этнографии. Ч-1. Л.  
Сунь Юнь., 1965. Сичуй цзунтун шилуэ (Общее обозрение западных границ). Тайбэй (А.И. Чернышевскийн зохиолоос ишлэв)  
Тэнгэрийн тэтгэсэн хааны богд сургаал.. Л. Дэндэвийн монгол орчуулга  
Циньдин хуаньюй Сиюй тучжи, "Высочайше утвержденное географическое описание Западного края". Т.1-5. Сянган  
Чернышев А.И., 1990. Общественное и государственное развитие ойратов в XYШ в. М.

## SUMMARY

I.Saruul, Z.Batsaikhan

### POPULATION SIZE OF "ZUUNGAR ULS"

*Population statistics is the main and solid evidence of economic and political development of any country and any community. During the Manch Chin Empire's aggressive invasion to Mongolia, the only part that been protecting its independence was the Western wing Oirad Mongolians. In the first half of XYIII century Oirads founded powerful ZuunGar Empire in the Central and Middle Asia. Its prosperity is tightly related with the growth of its population. Historical records and chronicles state that in XYIII century Mongolia's population was approximately 200000-600000. Still no other certain facts and figures about its population are available in history and no research work has been conducted so far. If we suppose this statistics - each Oirad household consisted of three people: a father, a mother, a child. Elderly people are not mentioned and this statement contradicts with historic reality. This situation would not have allowed them to control entire Central and Middle Asia and to be so powerful that they achieved social-economic prosperity. Therefore this figure is considered to be doubtful. According to the research works of foreign and Mongolian scholars each family had five people in average. It means 200000 families had one million people. In addition to this figure at least over 500000 people should be counted in the subordinate areas of the Middle Asia. Taking other factors influenced on the development of Oirad Mongolians into consideration authors believe that ZuunGar Empire population was 1.500.000-1.800.000 at the time.*